

Далайн тээвэр, боомт ашиглалт
хариуцсан албаны 2018 оны үйл
ажиллагааны тайлан




Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа Монгол Улсын Далайн захиргаа болон Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбооны хооронд төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх зорилгоор хамтын ажиллагааны санамж бичгийг 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан.

Энэхүү санамж бичгийн хүрээнд 2018-2019 онд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөгөөнд тусгаад байна. Үүнд:

- Тээвэр логистикийн салбарт тулгамдаж буй нийтлэг хүндрэл бэрхшээлийг тодорхойлох, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар хамтарсан хурал семинар зохион байгуулах;
- Салбарын боловсон хүчнийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлж оролцох;
- Тээвэр, логистикийн салбарт ажиллах мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн оюутнуудад салбарын талаар цогц мэдлэг, боловсрол олгоход чиглэгдсэн үйл ажиллагааг хамтран зохион байгуулах;
- Монгол улсын экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх механизмыг боловсронгуй болгоход санал, санаачлага гарган ажиллах;

Талууд улиралд нэг удаа уулзалт зохион байгуулж мэдээлэл солилцон, арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжилт үр дүнгийн талаар хэлэлцэж ажиллана.



Зураг дээр: Баруун гар талаас Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбооны Гүйцэтгэх захирал Б.Ганзориг, Далайн захиргааны Далайн тээвэр, боомт ашиглалт хариуцсан Ахлах мэргэжилтэн Б.Мөнхбат нар. (Үйл ажиллагааны төлөвлөгөө 2018.09.28-ны өдөр батлав.)



БНХАУ-ын Эрээн хотноо 2018.10.23-24-ний өдрүүдэд “Хятад-Монгол-Орос улсын тээврийн коридорыг хөгжүүлэх” сэдэвт БНХАУ болон Монгол Улсын тээвэр зуучлалын салбарын хамтарсан зөвлөгөөн боллоо. Тус зөвлөгөөнд Хятадын талаас төр болон хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөл 40 гаруй хүн, Монголын талаас 60 гаруй төлөөлөгч оролцсоноос ихэнх нь тээвэр зуучийн компанийн төлөөлөл байлаа.

Хамтарсан зөвлөгөөний үеэр Эрээн боомтын нэвтрүүлэх хүчин чадалтай холбоотойгоор үүсээд буй хүндрэлийн талаар хэлэлцэн, цаашид эдгээр асуудлыг хамтын хүчээр хэрхэн даван туулах тухай ярилцав.

Түүнчлэн, ачааны баримт бичгийн бүрдүүлэлтийн зөрүүтэй байдлаас үүдэн хил, гааль дээр үүсдэг удаан хугацаагаар саатаж, хүлээлт бий болсноор учирч буй эдийн засгийн хохирлыг хэрхэн бууруулах талаар санал бодлоо солилцон, асуудлыг хамтран шийдвэрлэх замаар Монгол Улсын нутгаар дамжин өнгөрч буй Хятад-Монгол-Орос Улсыг холбосон тээврийн коридорын өрсөлдөхүйц чадварыг нэмэгдүүлэх талаар зөвлөлдөв.

Энэхүү зөвлөлдөх уулзалтанд Монгол Улсын Далайн захиргааны ахлах мэргэжилтэн Б.Мөнхбат, мэргэжилтэн Д.Байгалмаа нар оролцож “Олон Улсын гэрээ хэлэлцээр болон Монгол Улсад олгогдсон эрх” сэдвээр илтгэл тавилаа.

Илтгэлд “Далайн эрх зүйн тухай” НҮБ-ын конвенцид тусгагдсан дамжин өнгөрөгч улсын эрх болон нутаг дэвсгэрээрээ дамжуулан өнгөрүүлж буй улсын үүрэг, хариуцлагыг холбогдох зүйл, заалт тус бүрээр тайлбарлах замаар транзит тээврийн харилцаанд оролцогчдын үйл ажиллагаандаа мөрдвөл зохих олон улсын хууль эрх зүйн хэмжээг тодорхойлон харуулахыг зорьсон.

Монгол Улсын Далайн захиргаанаас НҮБ-ын Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Олон улсын судалгааны төвтэй хамтран “ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ САНААЧЛАГА БОЛОН ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН САЛБАРТ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД” сэдэвт семинар, хэлэлцүүлгийг 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр НҮБ-ын Монгол улс дахь суурин төлөөлөгчийн газрын байранд зохион байгууллаа.

Семинар, хэлэлцүүлэгт Монгол Улсын Гадаад харилцааны яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрдэнэс Тавантолгой ХК, Шарын гол ХК, Үндэсний хөгжлийн газар, Гаалийн ерөнхий газар, Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо болон тээвэр логистикийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачид оролцлоо.

Семинар, хэлэлцүүлгийн гол зорилго нь Монголын тээвэр логистикийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд өдөр тутамд тулгардаг хүндрэл бэрхшээлийн талаарх тэдний саналыг сонсож, тээвэр логистикийн салбарын олон улсын гэрээ, эрх зүй, төрийн байгууллагуудын хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний талаар мэдээлэл өгөх байв.

Уг арга хэмжээний үер “Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын хөгжил, эдийн засгийн байдал болон Олон улсын судалгааны төвийн үйл ажиллагаа, ач холбогдлын” талаар, Дэлхийн худалдааны байгууллагын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр болон хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны үйл ажиллагааны” талаар, “Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжид итгэмжлэл олгох тухай хөтөлбөр, журмын” талаар, “Хөрш орнуудаар дамжин нүүрс гуравдагч оронд тээвэртэй тухай судалгааны ТАНИЛЦУУЛГА” талаар илтгэлүүдийг Далайд гарцгүй хөгжиж орнуудын олон улсын судалгааны төв, Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа газар, Гаалийн ерөнхий газар, Далайн захиргаанаас тус тус тавьж, хэлэлцүүлсэн.



2018 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ АЖЛЫН ЖАГ СААЛТ

Судалгааны ажлууд:

- Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүнийг ОХУ-ын “Восточный” далайн боомтоор дамжуулан гуравдагч орны зах зээлд тээвэрлэн хүргэх нөхцөл боломжийн тухай
- Монгол Улс Оросын Холбооны Улсын Алс Дорнодын боомтоор нүүрс дамжуулан тээвэрлэхэд хөрөнгө оруулж хамтран ажиллах нөхцөл боломжийн тухай (Вера боомт, Восточный боомт, Ванино боомт)
- Монгол Улсын бараа, бүтээгдэхүүнийг БНХАУ-ын “Жинжоу” далайн боомтоор дамжуулан тээвэрлэх нөхцөл боломж, зардлын тооцоолол
- Монгол Улсын Далайн захиргаа, Бүгд Найрамдах Итали Улсын Баруун Лигуриягийн тэнгисийн боомттой байгуулсан санамж бичгийн хүрээнд - Бүгд Найрамдах Итали Улсын Генуя далайн боомтыг ашиглан Европын зах зээлд Монгол Улсын экспортын бараа бүтээгдэхүүнийг гаргах нөхцөл боломжийн тухай